

“ТӨМӨР ЗАМААР ЗОРЧИГЧ, ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ”-ИЙН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Төмөр замын тээврийн тухай болон бусад холбогдох хууль, стандартыг хэрэгжүүлэх, тээвэрлэлттэй холбоотой харилцаанд тулгуурлан зорчигч, тээш, ачаан тээшийг аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангаж тээвэрлэхэд оршино.

1.2. Энэхүү дүрмийг төмөр замаар зорчих зорчигч, үйлчлүүлэгч, тэдгээрийн харилцаанд оролцогч ажилтан, тээш, ачаан тээш илгээгч ба хүлээн авагч нарын үйл ажиллагаанд мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх асуудлыг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2.2. Олон улсын зорчигч тээвэрлэлтийг олон улсын зорчигч тээврийн хэлэлцээрээр зохицуулна.

2.3. Зорчигчид үйлчлэх төв:

2.3.1. төмөр замын суурь бүтэц эзэмшигч нь төмөр замын зорчигчид үйлчлэх төвийн орчны тохижилт, арчлалт, засвар, үйлчилгээг хариуцна.

а) тасалбарын цэг, хүлээлгийн танхим, ариун цэврийн (хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдэд зориулсан тусгай тоног, төхөөрөмж) болон эх, хүүхдийн өрөөтэй болон эрүүл мэнд, нийтийн дэг журмыг сахиулах зэрэг үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна;

б) галт тэрэгний цагийн хуваарь, тээвэрлэлтийн тариф, үйлчилгээний цагийн хуваарь, иргэдэд үзүүлэх үйлчилгээний газрын байршил, зорчигч ба тээш, ачаан тээш тээвэрлэлтийн тариф, тээш олгох газрын ажиллах цагийн хуваарь, санал гомдлын дэвтэр, гэнэтийн ослын даатгалын хураамжийн үнэлгээ, үйлчилгээний газрууд (зоогийн газар, амрах байр, үсчин, зурагчин, шуудан ба үүрэн холбоо, эмнэлгийн цэг ба эмийн сан, лавлах товчоо зэрэг)-ийн бүдүүвч зураг, зорчигч болон тээш тээвэрлэхтэй холбоотой дүрэм, журам, шинээр хэрэгжүүлсэн нэмэлт үйлчилгээ, тэдгээрийн хураамж, цаг үеийн шуурхай мэдээ зэрэг мэдээллийг нээлттэй байршуулсан байна;

2.3.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулалтын бичвэр, дохио,цахим хэрэгслийг ашиглан мэдээллийг хүргэх боломжийг бүрдүүлсэн байна;

2.2.3. зорчигчийн тавцан, нүхэн гарцын орц, гарц нь хөгжлийн бэрхшээлтэй, хязгаарлагдмал хөдөлгөөнтэй иргэд хүртээмжтэй ашиглах боломжийг бүрдүүлсэн тусгай цахилгаан (лифт) болон явган шатаар тоноглогдсон байна.

2.3. Зорчигчид үйлчлэх төвийг тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр ашиглана;

2.4. Зорчих тасалбар /цаасан болон цахим/ нь зорчигч болон тээвэрлэгчийн хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох баримт бичиг мөн.

2.5. Тээвэрлэгч нь зорчих тасалбарыг тасалбар худалдаалах төв, цахим терминал, интернэтээр болон бусад аргаар худалдаалах ажлыг зохион байгуулна.

2.6. Зорчих тасалбар худалдах газрын үйл ажиллагаа нь зорчих тасалбарыг зорчигчдод аль болох түргэн шуурхай худалдаж, галт тэргэнд хоосон байр гаргахгүй байхаар зохион байгуулагдана.

2.7. Зорчигчид үйлчлэх үйлчилгээ нь стандартын шаардлага хангасан байна.

2.8. Тээвэрлэгчийн хүлээх эрх, үүрэг:

2.8.1. тээвэрлэгч нь зорчигчийн өмнө, зорчигч нь тээвэрлэгчийн өмнө харилцан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

а) төмөр замын ажилтнууд энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг баримтлан эрх үүргээ шударгаар хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ;

б) энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн төмөр замын байгууллагын ажилтанд хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасанд тооцон хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах ба энэ нь хуульд зааснаас бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;

в) энэхүү дүрмээр зохицуулсан харилцаанд оролцогч гадны байгууллага, иргэд, зорчигчтой холбоотой алдаа дутагдлыг энэ дүрэм болон бусад хууль тогтоомжийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

2.9. Зорчигчийг ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлж, тасалбарт заагдсан хүрэх өртөөнд цаг хугацаанд нь хүргэх үүрэгтэй.

2.10. Зорчигчийн тээш ба ачаан тээшийг хүлээж авснаас эхлэн олгох хүртэл тогтоосон журмын дагуу тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.11. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.12. Зорчигч тогтоосон хэмжээнээс илүү гар тээш тээвэрлэвэл тээшийн тарифаар тээврийн төлбөр авна.

2.13. Тээш хүргэх хугацаа хожимдуулсны нөхөн төлбөрийг очих өртөөн дээр үйлдсэн актыг үндэслэн төлнө.

2.14. Хэрэв бусад тээвэрлэгч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч, салбар зам эзэмшигч, тээвэр зуучлагчийн буруугаас үүссэн хариуцлагыг тээвэрлэгч хүлээсэн бол хохирлоо буруутай этгээдээс шаардах эрхтэй.

2.15. Зорчигч болон илгээгчээс тээш, ачаан тээшийг хүлээн авч төмөр замын өртөө /уг ажиллагаанд нээлттэй/ хүртэл тээвэрлэх үүрэгтэй.

2.16. Зорчигч тээвэрлэх гэрээний дагуу зорчигч нь зорчих тасалбарын үнийг төлөх, тээвэрлэгч нь зорчигчийг хүрэх газарт хүргэх, галт тэргэнд зорчих тасалбарт заасан суудлаар хангах үүрэгтэй.

2.17. Зорчих тасалбарын дагуу зорчигчийг хүрэх газарт хүргээгүй, эсхүл тээвэрлэлтийг үргэлжлүүлэхээс татгалзсан бол очих газар хүртэл гарч болох бүхий л зардлыг гэрээний дагуу зорчигчид төлөх үүрэгтэй.

2.18. Зорчих тасалбар худалдах газар нь доорх тохиолдолд зорчих тасалбар худалдахаас татгалзах эрхтэй:

- галт тэргэнд сул байр байхгүй;
- иргэний үнэмлэх эсхүл бусад биеийн байцаалтгүй;
- согтууруулах ундаа хэрэглэсэн этгээд;
- мансуурсан этгээд.

2.19. Тээвэрлэгч дараах тохиолдолд зорчигчийг цааш тээвэрлэхээс татгалзана. Үүнд:

а) зорчигч аяллын журам зөрчих буюу вагонд зорчигчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэсэн тохиолдолд;

б) бусад зорчигчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, гэм хор учруулахуйц зорчигч /сэтгэцийн хүнд өвчтэй зэрэг/ байвал түүнд тусгайлан суудал гаргаж өгөх буюу суудал гаргаж өгөх бололцоогүй нөхцөлд зорчигчийг эмнэлгийн байгууллага бүхий өртөөнд галт тэрэгнээс буулгана.

2.20. Мартсан болон алдсан эд юмс:

2.20.1. эд юмс нь өртөө болон эргэлтийн өртөөнд ирэхдээ галт тэргэн дотроос эсвэл тус өртөөнд ирэх хоорондын замаас олдсон бол тэмдэглэл хөтөлж цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

2.21. Зорчигч дараах эрхтэй:

2.21.1. зорчих тасалбар худалдан авах;

2.21.2. зорчигчийн нэг зорчих тасалбараар 5 (тав) хүртэлх насны тусдаа суудал эзлэхгүй (2) хоёр хүүхдийг үнэ төлбөргүй харгалзан авч явах;

2.21.3. 0-12 (арван хоёр) хүртэлх насны хүүхдийг хөнгөлөлттэй үнээр хамт харгалзан авч явах;

2.21.4. хөгжлийн бэрхшээлтэй болон хязгаарлагдмал хөдөлгөөнтэй зорчигч нь туслах хэрэгсэл /тэргэнцэр, таяг гэх мэт/-ийг үнэ төлбөргүй авч явах;

2.21.5. энэхүү дүрэмд заасан ёсоор зорчих тасалбарыг буцаах, тээвэрлэгчээс зорчих тасалбарын болон тээш тээвэрлэлтийн үнийг буцааж авах, хугацааг өөрчлөх;

2.21.6. өмнөх галт тэргээр зорчих тасалбар /сул суудалтай тохиолдолд тасалбарт өөрчлөлт оруулан/-аар дараагийн галт тэргээр аялах;

2.21.7. зорчих тасалбарыг хаясан үрэгдүүлсэн бол энэхүү дүрэмд заасны дагуу тээвэрлэгчид мэдэгдэн, зорчих тасалбарыг дахин хэвлүүлж авах;

2.21.8. зорчигч хүсвэл аяллын явцад зэрэглэл бууруулж вагонд шилжин сууж болох бөгөөд анх төлсөн тээврийн хөлсний зөрүүг буцааж олгохгүй.

2.22. Зорчигч дараах үүрэгтэй:

2.22.1. зорчих тасалбар худалдаж авах, галт тэргэнд суух, эсхүл аяллын зам зуурт зорчих тасалбар шалгуулах үедээ хувийн бичиг баримтаа үзүүлэх;

2.22.2. галт тэргэнд суух болон аяллын хугацаанд зорчих тасалбарыг биедээ авч явах;

2.22.3. зорчигч үйлчилгээний төвийн болон зорчигчийн вагон ашиглах журам, нийтийн хэв журмыг сахин биелүүлэх;

2.22.4. тээвэрлэгчийн эд хөрөнгөд ариг гамтай хандаж, эвдэж гэмтээхгүй байх галын аюулгүй байдлыг хангах;

2.22.5. галт тэргэнд аюултай ачаа биедээ авч явахыг хориглоно;

2.22.6. галт тэргээр зорчих хугацаанд гэнэтийн ослын даатгалд даатгуулах үүрэгтэй;

2.22.7. аяллын үед бусад зорчигч нарт саад болохгүй, төвөг учруулахгүй байх;

2.22.8. зорчих тасалбарыг бусдад шилжүүлж болохгүй;

2.22.9. төмөр замын тээврийн хэрэгсэл болон буудлын эд хогшилд ариг гамтай хандан олон нийтийн хэв журмыг чанд сахиж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон төмөр замын байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмын талаар мэдээллийн самбар, орон нутгийн болон үндэсний шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн дүрэм, журмыг биелүүлэх үүрэгтэй.

2.23. Зорчих тасалбар худалдаалах:

2.23.1. зорчих тасалбар нь тээвэрлэгч, зорчигч хооронд тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт бөгөөд батлагдсан маягтын дагуу бичигдсэн байна;

2.23.2. зорчих тасалбарыг, галт тэрэгний аялах цагийн хуваарь өөрчлөгдөхөөс бусад тохиолдолд 2 сарын өмнөөс худалдаална;

2.23.3. зорчих тасалбар худалдах ажиллагааг галт тэрэг хөдлөхөөс 15 минутын өмнө зогсооно;

2.23.4. галт тэрэгний зорчих тасалбар худалдах газрын ажиллах цагийг галт тэрэгний цагийн хуваарьтай уялдуулан тээвэрлэгч тогтооно;

2.23.5. галт тэргээр зорчих тасалбарт явах хүрэх өртөөний нэр, галт тэрэг, вагон, зорчих байрын дугаар, явах болон олгосон огноо, үнэ, зорчигчийн овог нэр, регистрийн дугаар, санамжийг тус тус бичнэ;

2.23.6. зорчих тасалбар нь тэмдэглэсэн хугацаанд, аялал эхлэх өртөөнөөс дуусах өртөө хүртэл хүчинтэй;

2.23.7. зорчих тасалбар худалдах газартай өртөө, зөрлөгөөс галт тэргэнд тасалбаргүй суусан зорчигчид тасалбар худалдах явуулын нярав /цаашид “явуулын нярав” гэх/ тасалбарыг нэмэгдэлтэй тарифаар худалдана. Нэмэгдлийн хэмжээг тээвэрлэгч тогтооно;

2.23.8. зорчигч аяллын явцад хүсвэл сул суудал байгаа тохиолдолд зэрэглэлээ ахиулж болно. Харин нэмэгдэл төлбөрийг шилжин суух эхний өртөөнөөс авна.

2.24. Аяллын хугацааг өөрчлөх:

2.24.1. зорчигч хүсвэл аяллын хугацааг өөрчилж болох бөгөөд нэмэлт төлбөрийг тарифт заасны дагуу төлнө;

2.24.2. зорчигч хоорондын өртөө, зөрлөгт түр буух бол 10-аас дээшгүй хоногоор саатаж болох бөгөөд энэ тухай тэмдэглэл хийлгэнэ.

2.25. Зорчих тасалбар буцаах:

2.25.1. галт тэрэгний хөдөлгөөн ямар нэг шалтгаанаар саатсан үед зорчигч аяллаа үргэлжлүүлэхээс татгалзвал төмөр зам нь зорчигчийн мэдүүлгийн үндсэн дээр зорчоогүй зайн үнийг буцааж олгоно. Үүнийг зорчигчоос гаргасан бичмэл хүсэлтийг үндэслэн шийдвэрлэнэ;

2.25.2. зорчигч зорчих тасалбараа үрэгдүүлсэн, гээгдүүлсэн тохиолдолд зорчих тасалбар худалдан авсан зорчигчийн талаарх мэдээлэл зорчих тасалбар худалдаалалтын баазад хадгалагдан үлдсэнийг тодорхойлсон нөхцөлд иргэний биеийн байцаалтыг мэдүүлсний үндсэн дээр тасалбарын үнийг дахин төлөхгүй байж болох ба тасалбар нөхөн олгохтой холбогдуулан нэмэлт үйлчилгээний хураамжийг тарифын дагуу төлж тасалбар дахин авч болно.

2.26. Зорчих нөхцөл:

2.26.1. зорчигчийг вагонд суух үед вагоны үйлчлэгч нь зорчих тасалбарын мэдээлэл нь биеийн байцаалттай тохирч байгаа эсэх, зөвшөөрөгдсөн хэмжээний гар тээш авч яваа эсэхэд хяналт тавина;

2.26.2. галт тэрэг 2 хүртэл минутын зогсолттой өртөө, зөрлөгт зорчигчийг галт тэрэгний аль ч вагонд оруулж болно;

2.26.3. вагоны үйлчлэгч зорчигч буух өртөөндөө хүрэлцэн ирэхийн өмнө ашиглагдсан тасалбар болон бусад тээврийн бичиг баримтыг эзэнд нь буцааж өгнө;

2.26.4. буусан зорчигч өөрийнхөө тээшийг зорчих тасалбарт заасан өртөө хүртэл илгээхийг зөвшөөрөөгүй тохиолдолд тээшний тасалбарыг үндэслэн уг зорчигчийн буусан өртөөнд тээшийг олгох ба бололцоогүй бол уг тээшийг очих өртөө хүртэл илгээнэ.

2.27. Нэмэлт үйлчилгээ:

2.27.1. унтлагын зориулалттай вагонд төлбөртэй цагаан хэрэглэлээр үйлчилнэ;

2.27.2. зорчигчийн хүсэлтээр цай, кофе, цэвэр ус, буцалсан ус, ахуйн хэрэгцээний зүйлс зэргээр тогтоосон тарифын дагуу үйлчилнэ;

2.27.3. зорчигчийн аялж байсан вагон ямар нэгэн шалтгаанаар салгагдсан тохиолдолд зорчигчийн аюулгүй байдлыг хангахаас гадна цагаан хэрэглэлээр үнэгүй үйлчилнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЦАХИМ ТАСАЛБАР БОРЛУУЛАХ, БУЦААХ НӨХЦӨЛ

3.1. Тээвэрлэгч нь цахим тасалбарын загварыг батална.

3.2. Тасалбар худалдаалах үйлчилгээг цахим хэлбэрээр дамжуулан гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж болно.

3.3. Зорчигч цахим тасалбарын өгөгдлийг хүлээн авснаар тээвэрлэгчтэй тээврийн гэрээ байгуулсанд тооцно.

3.4. Цахим тасалбарт энэ дүрмийн 2.22.5-т заасан мэдээллийг агуулсан байна.

3.5. Зорчигч нь цахим тасалбарыг хэвлэмэл эсвэл зурган байдлаар (олон улсад хэвлэмэл байдлаар), биеийн байцаалтын хамт шалгуулна. Зөрчил илэрсэн тохиолдолд зохих хуулийн дагуу хариуцлага хүлээж, дахин зорчих тасалбар авна.

3.6. Зорчигч цахим тасалбарын аяллын хугацааг өөрчлөх ба буцаах үйлчилгээ авах бол тасалбар худалдаалах цэгт өөрийн биеэр ирэх эсвэл уг үйлчилгээг цахим хэлбэрээр авч болно.

3.7. Цахим тасалбарын мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалыг бусдад задруулсан тохиолдолд холбогдох байгууллага нь бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАР ТЭЭШ ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ НӨХЦӨЛ

4.1. Гар тээш тээвэрлэх:

4.1.1. гар тээш нь сав, баглаа, боодол бүхий хэмжээгээрээ вагоны гар тээшний байранд хялбар багтах, бусад зорчигчдод саад болохооргүй байна;

4.1.2. зорчигч нь зорчих тасалбараар 36 кг-аас илүүгүй жинтэй, 0-12 хүртэлх насны хүүхдийн тасалбараар 15 кг хүртэл жинтэй 40x60x80 см-ээс хэтрэхгүй хэмжээтэй нэг гар тээшийг үнэ төлбөргүй авч болно;

4.1.3. гар тээшинд зорчигчийн аяллын туршид хэрэглэх хүнсний болон хувийн хэрэгцээний эд зүйлс, ариун цэврийн хэрэглэл, ахуйн зориулалттай бараа орно;

4.1.4. гар тээшний бүрэн бүтэн байдлыг зорчигч өөрөө хариуцна;

4.1.5. зорчигч нь галт тэргэнд аюултай ачаа биедээ болон гар тээшинд авч явахыг хориглоно;

4.1.6. гэрийн тэжээвэр амьтныг авч явах бол тасалгаат вагоны 1 тасалгааг /купе/ бүтнээр нь худалдан авна;

4.1.7. тусгайлан хориглоогүй бол биеийн байцаалттай, 30x40 см хэмжээтэй 1-5 кг хүртэл гэрийн тэжээвэр амьтныг бусдын аюулгүй байдлыг хангасан хамгаалах хэрэгсэлтэй, хайрцаг, тор зэрэг зориулалтын саванд тээвэрлэнэ;

4.1.8. Зорчигч тогтоосон хэмжээнээс их овор, хэмжээтэй гар тээш тээвэрлэвэл суусан өртөөнөөс очих өртөө хүртэл тээврийн хөлсийг тээшийн тарифын дагуу төлүүлнэ.

4.2. Гар тээш хадгалах:

4.2.1. зорчигч үйлчилгээний төв нь гар тээш хадгалах байртай байна;

4.2.2. бусдын эд зүйлд хор нөлөө үзүүлж болохуйц гар тээшийг хадгалуулахаар өгсөн этгээд үүсэж болох бүх хариуцлагыг өөрөө хүлээнэ;

4.2.3. гар тээшний эзэн тээш хадгалуулсны хөлсийг тогтоосон тарифын дагуу төлнө;

4.2.4. гар тээшээ 30 хоногийн дотор хүлээн авахгүй тохиолдолд тээвэрлэгч, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран акт тогтоож, уг гар тээшийг худалдан борлуулж хадгалалтын төлбөрт тооцно. Борлуулах боломжгүй тохиолдолд устгах арга хэмжээ авна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭШ, АЧААН ТЭЭШИЙН ТЭЭВЭРЛЭЛТ

5.1. Тээш, ачаан тээш тээвэрлэлт:

5.1.1. тээш, ачаан тээшийн төлбөрийн баримт нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсныг нотлох бичиг баримт болно. Ачаан тээш тээвэрлэхэд зорчигчийн тасалбар шаардахгүй;

5.1.2. тээвэрлэгч нь илгээгчийн тээш, ачаан тээшийг тээшний вагон холбогдсон хамгийн эхний галт тэргээр явуулах боловч зорчигчийн тээш, ачаан тээшийг тэргүүн ээлжинд илгээх зарчим баримтална;

5.1.3. зорчигчийн тасалбарт заасан замналаар явуулах тээш, ачаан тээшийг зорчигчийн зорчиж байгаа галт тэргээр, эсхүл тээшний вагон холбогдсон эхний галт тэргээр явуулна;

5.1.4. тээвэрлэлтэд тээш, ачаан тээшээр хүлээлгэн өгч байгаа эд зүйлс нь хэмжээ, сав, баглаа боодол, шинж чанарын хувьд тээшний вагонд ачиж буулгахад

хүндрэл үүсгэхгүй, тээвэрлэгчийн эд зүйл, бусад зорчигчийн тээш, ачаан тээшийг гэмтээхээргүй байна;

5.1.5. тээш, ачаан тээш тээвэрлэх гэрээний дагуу тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг хүрэх газарт хүргэх, илгээгч нь ачаа хүргэлтийн төлбөрийг төлөх үүрэгтэй;

5.1.6. тээвэрлэлтийг хэд хэдэн тээвэрлэгч гүйцэтгэсэн тохиолдолд тэдгээр нь ачаа илгээгч, эсхүл ачаа хүлээн авагчийн өмнө ачаа, тээш, ачаан тээшийг үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасан болон хүргэх хугацааг нь хожимдуулсны хамтын хариуцлага хүлээнэ;

5.1.7. тээвэрлэгч нь тээш, ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авсан мөчөөс хүлээн авагчид олгох үе хүртэл түүний бүрэн бүтэн байдлыг хангана;

5.1.8. үнэ зарлаж тээвэрлэлтэд хүлээн авсан тээш, ачаан тээшийг алдаж үрэгдүүлсэн, дутаасан, гэмтээж муутгасан бол тээвэрлэгч зарласан үнийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ;

5.1.9. тээш, ачаан тээшийг илгээгч нь тээвэрлэхийг хориглосон ачаа тээвэрлэх, тээвэрлэхээр завдахыг хориглоно;

5.1.10. ачаа илгээгч нь вагон, чингэлэгт ачаа ачихдаа Монгол Улсын хуулиар хориглосон ачаа ачих, ачаанд нуухыг хориглоно;

5.1.11. тээш, ачаан тээш хүргэх хугацаа хожимдуулсан тохиолдолд тээвэрлэгч нь /өөрийн буруугаас болоогүй гэдгээ нотолж чадаагүй бол/ "Иргэний хуулийн 76 дугаар зүйл"-ийг баримтална;

5.1.12. тээвэрлэгч дараах нөхцөлд ачаа, тээш, ачаан тээшинд тээврийн акт тогтооно:

- тээвэрлэлтийн бичиг баримтад заасан жин, нэр зөрсөн;
- тээш, ачаан тээш гэмтсэн, муудсан, үрэгдсэн;
- бичиг баримтгүй тээш, ачаан тээш илэрсэн;
- тээш, ачаан тээшгүй тээвэрлэлтийн бичиг баримт илэрсэн;
- хулгайлагдсан, дутсан ачаа, тээш, ачаан тээшийг тээвэрлэгчид буцаан өгсөн;

5.1.13. тээвэрлэгч тээвэрлэлтийн бичиг баримтад тээврийн акт тогтоосон тэмдэглэгээг хийнэ;

5.1.14. гомдлыг хүлээн авахаас бүрэн болон хэсэгчлэн татгалзсан, эсхүл гомдлыг судлах хугацаанд тээвэрлэгч хариу өгөөгүй бол тээвэрлэгчид холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргаж болно;

5.1.15. зорчигч, тээш, ачаан тээш хүргэх хугацаа зөрчсөний торгуулийг зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэмд заасны дагуу тээш, ачаа тээшийг хүлээн авагч, зорчигчийн гаргасан өргөдөл, эрх бүхий этгээдээс тогтоосон тээврийн актын дагуу төлнө;

5.1.16. зорчигч, тээш тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч явуулна;

5.1.17. тээвэрлэгч нь зорчигч тээш, ачаан тээшийн тарифын өөрчлөлтийг хуульд заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөхөөс 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.2. Тээш хүлээн авах, тээвэрлэх:

5.2.1. “тээш” гэж тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн зорчигчийн эд зүйлсийг хэлнэ;

5.2.2. нэг байр эзлэх тээш нь 50 кг-аас ихгүй байх ба нэг зорчих тасалбараар тээвэрлүүлэх тээшийн нийт хэмжээ 200 кг-аас ихгүй байна;

5.2.3. бүрэн бүтэн бус сав, баглаа, боодолтой тээшийг тээвэрлэлтэд хүлээж авахгүй. Бусад тээшинд гэм хор учруулах, бохирдуулах, эвгүй үнэртэй ачаа, галт зэвсэг, галын аюултай, түргэн ба өөрөө шатах, тэсрэх, дэлбэрэх, цацраг идэвхт, идэмхий болон хордуулах бодис зэрэг хууль тогтоомжоор тээвэрлэхийг хориглосон зүйлс, мөн түүнчлэн хорио цээрийн голомтод байсан тэжээвэр амьтан, тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахгүй;

5.2.4. тээшийг галт тэрэг хөдлөхөөс нэг цагаас доошгүй хугацааны өмнө тээвэрлэлтэд хүлээн авна;

5.2.5. тээш хүргэх хугацааг эзэн нь зорчиж буй тээшний вагон бүхий галт тэрэгний эсвэл зорчигчийн хүссэн ёсоор тээшийг илгээсэн галт тэрэгний замд явах хугацаагаар тус тус тодорхойлно;

5.2.6. зорчигч аяллын замдаа тээш ачаан тээшээ авахыг хүсвэл галт тэрэгний даргаар дамжуулан эсвэл өөрийн биеэр тээш, түгээгчид урьдчилан мэдэгдэнэ;

5.2.7. тээвэрлэсэн тээшийн сав, баглаа, боодол гэмтээгүй тохиолдолд ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан хариуцлагыг тээвэрлэгч хүлээхгүй;

5.2.8. онцгой болгоомж шаардсан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахдаа талууд техникийн нөхцөл, тээвэрлэлтийн шаардлагыг харилцан тохиролцоно;

5.2.9. Зорчигч тээш тээвэрлэлтэд хүлээлгэн өгөхдөө түүнд үнэ зарлаж болох бөгөөд төлбөрийг тарифын дагуу төлнө. Хэд хэдэн тээш өгсөн бол тээш тус бүрд эсвэл нийтэд нь үнэ зарлаж болно;

5.2.10. Төмөр замын ажилтан зарласан үнийн зөв эсэхэд эргэлзвэл тээшийг задалж үзүүлэхийг шаардаж болох ба зорчигч татгалзсан тохиолдолд тээвэрлэлтэд хүлээн авахгүй.

5.3. Гэрийн тэжээвэр амьтан тээвэрлэх:

5.3.1. бичиг баримттай гэрийн тэжээвэр амьтныг замдаа шилжүүлэн ачилтгүйгээр тээвэрлэлтэд хүлээн авах бөгөөд хооллох арчлах ажлыг эзэн нь хариуцна;

5.3.2. гэрийн тэжээвэр амьтныг бусад тээш болон вагоныг гэмтээхгүй, бохирдуулахгүй, байх боломжоор хангасан зориулалтын сагс, тор, саванд тээвэрлэнэ. Тор, сав нь тээвэрлэх амьтдын тоо, хэмжээнд тохирсон байх шаардлагатай бөгөөд хэт овортой байж болохгүй. Нэг байрны хэмжээ нь 50 кг-аас хэтэрч болохгүй. Гэрийн тэжээвэр амьтныг галт тэрэг хөдлөхөөс нэг цагийн өмнө тээвэрлэлтэд хүлээн авна.

5.4. Ургамал, суулгац тээвэрлэх:

5.4.1. бусад тээшийг бохирдуулахааргүй, сав, баглаа, боодол нь тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангасан, гарал үүслийн бичигтэй ургамал бут, суулгацыг тээшээр тээвэрлэж болно. Тээшийг тээвэрлэлтэд тухайн галт тэрэг хөдлөхөөс 2 цагийн өмнө хүлээн авна. Тээш тус бүрийн хүндийн жин 50 кг, өндөр нь 2 м-ээс хэтэрч болохгүй;

5.4.2. тээшийн дутагдал гэмтэл тээвэрлэгчийн буруугаас болсон бол хохирлыг тээш, ачаан тээш тус бүрийн зарласан үнийн дагуу, хэрэв зарласан нэг үнэтэй байвал дутсан тээш, ачаан тээшийн жинтэй шууд /пропорциональ/ хамаарлаар, хэрэв зорчигч тээшиндээ үнэ зарлаагүй бол дутагдсан хүндийн хэмжээгээр хохирлыг тогтоосон тарифын дагуу төлнө;

5.4.3. тээш алга болсонд тооцогдож, эзэнд нь нөхөн төлбөр төлсний дараа уг тээш чанар, хэмжээ алдагдаагүй олдвол нөхөн төлбөрийг буцаан авч, тээшийг эзэнд нь хүлээлгэн өгнө.

5.5. Тээшийг хадгалах:

5.5.1. өртөөнд ирүүлсэн тээшийг ирсэн өдрөөс эхлэн хүлээн авагчид олгох хүртэлх хугацаанд хадгалсны төлбөрийг тээвэрлэгчийн тогтоосон тарифын дагуу зорчигчоос авна.

5.6. Нэхэмжлээгүй тээшийг борлуулах:

5.6.1. зорчигч тээшээ аваагүй нөхцөлд энэхүү дүрмийн 4.2.7 зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

АЧААН ТЭЭШ ХҮЛЭЭН АВАХ БА ТЭЭВЭРЛЭХ НӨХЦӨЛ

6.1. Ачаан тээш хүлээн авах, тээвэрлэх:

6.1.1. “ачаан тээш” гэж хүн, хуулийн этгээдээс тээшийн вагоноор тээвэрлүүлэхээр зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн эд зүйлсийг хэлнэ;

6.1.3. тээвэрлэлтэд хүлээн авах нэг байр ачаан тээшийн жингийн хязгаарыг тээвэрлэгч тогтооно.

6.1.4. дараах ачаан тээшийг эхний ээлжид тээвэрлэнэ:

- а) сонин, бусад өдөр тутмын тогтмол хэвлэл;
- б) түргэн гэмтэж, муудах бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн;
- в) зөвшөөрөгдсөн гэрийн тэжээвэр амьтан;
- г) шарил.

6.1.5. түргэн муудах хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүнийг тээшийн вагонд тээвэрлэхээр хүлээн авахдаа түүнийг тээвэрлэх хугацаа, зайг гэмтэж муудахгүй тээвэрлэгдэх боломжтой эсэхийг тооцож хүлээн авна. Жилийн дулааны болон хүйтний улирлыг дараах байдлаар тооцно. 05 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацааг дулааны, 10 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацааг хүйтний улирал гэнэ;

6.1.6. дулааны улиралд ирсэн ачаан тээшийг тээвэрлэгч 6 цагаас дээш хадгалахгүй;

6.1.7. түргэн гэмтэж, муудах ачааг ачаан тээшээр тээвэрлэхэд галт тэрэг хөдлөхөөс 2 цагийн өмнө хүлээн авна;

6.1.8. түргэн гэмтэж, муудах ачаан тээш нь гэрээт хугацаанд хүргэгдсэн боловч тээвэрлэгчээс үл хамаарах шалтгаанаар шинж чанар муудсан тохиолдолд тээвэрлэгч гэм буруугүй болохоо нотолж, хариуцлагаас чөлөөлөгдөнө;

6.1.9. тээвэрлэлтэд хүлээж авсан ачаан тээшийн сав баглаа боодол гэмтээгүй анхааруулах тэмдэггүй мөртлөө дотор нь түргэн муудах ачаа (мах, сүү, ногоо, жимс г.м.), хагарч эвдрэх хэврэг ачаа (шил, шаазан эдлэл, телевизор г.м.) нь гэмтсэн байвал уг хохирлыг тээвэрлэгч хариуцахгүй.

6.2. Тээвэрлэлтэд хүлээн авах:

6.2.1. тээвэрлэгч нь ачаан тээшийн сав, баглаа, боодол тээвэрлэлтийн шаардлага хангасан эсэхийг шалгасны дараа ачаа илгээгч захиалгын маягтыг бөглөж өгнө. 6.2.3. Ачаан тээшийн нэр зөв эсэх талаар эргэлзээ гарсан тохиолдолд төмөр замын байгууллага ачааны сав, баглаа, боодлыг задлах шаардлага тавих эрхтэй. Ачаа тээшийг задалж үзэхийг илгээгч эс зөвшөөрвөл түүнийг тээвэрлэлтэд хүлээж авахгүй;

6.2.2. илгээгч нь хүсвэл ачаан тээшиндээ үнэ зарлаж болох бөгөөд хураамжийг тарифт заагдсаны дагуу төлнө;

6.2.3. зорчигчийн үнэ зарласан байдал барааны нэр төрөл, тоо ширхэг нь бодит үнэтэй тохирохгүй байвал явуулах өртөө ачаан тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзана.

6.3. Ачаан тээшийг тавьж олгох:

6.3.1. тээвэрлэгч ачаан тээш ирсэн тухай мэдээллийг хүлээн авагчид хүргэнэ.

6.4. Ачаан тээшийг хадгалах:

6.4.1. ачаан тээшийн өртөөнд хадгалсан хөлсийг тээвэрлэн ирсэн өдрөөс хүлээлгэн өгсөн өдөр хүртэлх хугацаагаар тооцож, тогтоосон тарифын дагуу төлүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

7.1. Тээвэрлэлтэд хяналт тавих:

7.1.1. төмөр замын тээврийн аюулгүй байдал, тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээний чанар хууль тогтоомж, стандартын шаардлагад хангаж буй эсэхэд холбогдох эрх бүхий албан тушаалтан хяналт тавина.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ЗОРЧИГЧ, ТЭЭШ, АЧААН ТЭЭШ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТАРИФ

8.1. Тээвэрлэгч нь төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.20-д заасан аргачлалын дагуу тариф тогтооно.

8.2. Зорчигчоос гэнэтийн ослын даатгалын хураамжийг тээвэрлэгчээс даатгалын компанитай байгуулсан гэрээнд заасан хэмжээгээр хураана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАРИМ ЗОРЧИГЧИЙГ ТЭЭВЭРЛЭХ ОНЦГОЙ НӨХЦӨЛ

9.1. Зарим зорчигчийг тээвэрлэх онцгой нөхцөл:

9.1.1. тээвэрлэгч нь олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээн, аялал жуулчлал болон арга хэмжээнд зохион байгуулалттайгаар оролцож буй ерөнхий боловсролын сургуулийн хэсэг, бүлэг сурагчдад олон улсын болон орон нутгийн зорчигчийн галт тэргээр зорчиход хөнгөлөлт үзүүлж болно.

9.1.2. зорчигчийн галт тэргээр зорчих хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд тээвэрлэгчийн тогтоосон тарифын дагуу хөнгөлөлт үзүүлж болно.

9.2. Зоогийн вагон аялуулах:

9.2.1. тээвэрлэгч гэрээний үндсэн дээр зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд зоогийн вагон холбон аялуулж болно.

9.3. Ачааны вагоноор тээш тээвэрлэх:

9.3.1. зорчигчийн галт тэргэнд ачааны вагон залгаж тээш, ачаан тээш тээвэрлэх тохиолдолд тээш, ачаан тээш тээвэрлэх тарифт үнэлгээгээр зохицуулна.

9.4. Шарил тээвэрлэх:

9.4.1. авсалсан шарилыг ачааны болон зорчигчийн галт тэргээр тусад нь вагонд тээвэрлэж болох бөгөөд шарил төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч засаг захиргаа ба эмнэлгийн байгууллагын зөвшөөрөл,

магадалгааг явуулах өртөөнд үзүүлнэ. Дээрх бичиг баримт нь тээврийн бичиг баримтын хамтаар очих өртөөн дэх хүлээн авагчид очно. Шарилыг сайн гагнасан төмөр авсанд буюу давирхайдсан модон хайрцагт хийж доторх хоосон зайг дүүргэх материал /үртэс, нүүрс, хүхэр, шохой зэрэг/-аар чигжсэнийг шалган хүлээн авч тээвэрлэнэ;

9.4.2. тээшийн ба шуудангийн вагоноор шарилыг тээвэрлэвэл тээвэрлэх зардлыг ачаан тээшийн тарифын үнэлгээ, 300 кг-аар тооцож төлбөрийг авна;

9.4.3. тээшийн ба шуудангийн вагоноор чандар тээвэрлэх тохиолдолд ачаан тээшийн тарифын үнэлгээ, 100 кг-аар тооцож, төлбөрийг авна;

9.4.4. шарилыг дагалдаж хүн заавал явна. Дагалдагч нь ямар нэг шалтгаанаар галт тэрэгнээс хоцорвол шарилыг саатуулах шалтгаан болохгүй. Дагалдагч нь бусад зорчигчийн нэгэн адил зорчих тасалбар худалдан авч зорчино.

9.5. Хувийн эзэмшлийн вагоноор зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх:

9.5.1. зорчигчийн ба ачааны галт тэрэгний бүрэлдэхүүнд хувийн эзэмшлийн вагон явах тохиолдолд тээвэрлэгч, вагоны эзэмшигчтэй гэрээ байгуулна.

9.6. Зорчигчийн вагон түрээслэх:

9.6.1. тээвэрлэгч нь тогтоосон тарифын дагуу зорчигчийн вагоны түрээсэлж болно.

---oOo---